



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг нь үндэслэн хур тунадас нэмэгдүүлэх, хил дамнасан түймэр, тал хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд цаг агаарт зориудаар нөлөөлөх "Онон бороо-3" хээрийн экспедицийг байгуулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Экспедицийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвийн санхүүжилтээр шийдвэрлэн, цаг уур, орчны хяналт шинжилгээний /ШЗ.XIV.01.01.2023/ зааврыг мөрдөж ажиллахыг Дорнод аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Г.Гарамхишиг)-д даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Технологи, инновацийн хэлтэс (А.Батболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА